


БАТЛАВ
 БАГАНУУР-УС ААТУГ-ЫН
 ЗАХИРАЛ *J. Энхбат* Ж.ЭНХБАТ
 2022 оны ... сарын...ны өдөр




ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №2/2022

1	Барилга байгууламжийн нэр, зориулалт, байршил	БНД 5-р хороо Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /14*18 харьцаатай/
2	Нийт усны хэрэглээ	Цэвэр усны 1,5 м ³ /хоног Технологийн усны - м ³ /хоног Галын усны - л/с Бохир усны 1,5 м ³ /хоног
3	Цэвэр усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр, даралт	Ус дулааны худаг ВК-11-9'-т цэвэр усны шугамыг 40 мм-ийн голчтой шугамаар холболт хийнэ. Шугамын даралт P=2.0 ата
4	Бохир усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр	Ариутгах татуургын шугамыг Нарийн хэсгийн бохир ус цуглуулах резервуарт Ø150 мм-ийн голчтой хуванцар шугамаар холбоно.
5	Халаалтын шугамын холболт хийх байршил, шугамын диаметр	Ус дулааны худаг ВК-11-9'-т халаалтын Ø76/76 шугамаас Ø50/50 мм-ийн голчтой ган шугамаар холболт хийнэ.
6	Нэмэлт нөхцөл	Ус хангамж: ВК-11-9 худгаас ВК-11-9' хүртэлхи цэвэр усны шуамыг өргөтгөнө. Ариутгах татуурга: "Дүүрэн чандмань" мал эмнэлгийн бохирын шугамыг өргөтгөж холболт хийнэ. Дулаан хангамж:
7	Тавигдах шаардлага	<ol style="list-style-type: none"> 1. Барилгыг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн дагуу цэвэр усны шугамын тэнхлэгээс 5м, бохир усны шугамын тэнхлэгээс 6м, халаалтын шугамаас 5 м зайд барих. 2. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 15.1.10 дагуу хангагч нь хэрэглэгчийн шугамаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөл олгож, батлагдсан ажлын зураг төслийн дагуу дараагийн хэрэглэгчийг холбуулах 3. Цэвэр, бохир ус, халаалтын шугамын угсралт, шахалт, туршилтын үед хангагч байгууллагын хяналтын инженерийг байлцуулж, ил далд ажлын акт үйлдэнэ. 4. Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа-2 жил

		<p>5. Шугам сүлжээний ажлын үед шугам зөөх, дайрч гарах, зам бут сөөг эвдэгдэхэд гарах зардлыг төсөвт тусгаж сэргээх шаардлагатай.</p> <p>6. Шугам сүлжээ нь стандартын шаардлага хангасан шинэ байх ба сувгийг стандартын дагуу хийгдсэн төмөр бетон суваг, даацын хавтан ашиглавал зохино.</p>
7	Объект барих дээд газрын шийдвэр	БНДЗД-ын 2017 оны А/242 тоот захирамжаар ӨЭМТөв барих 600м2 талбай бүхий газар
8	Хэрэглэгчийн нэр, утас	БНДЗДТГ-ын ДБҮҮХ хот байгуулалт барилга байгууламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн 99263282
9	Техникийн нөхцөлтэй холбоотой тодруулга	

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ БОЛОВСРУУЛСАН:
 ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР *М.Мунзур*, Ж.МӨНХЦЭЦЭГ



ЕРӨНХӨЙ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №06/2021

Багануур дүүрэг

1. Хэрэглэгчийн нэр: "ЗДТГ"
2. Барилгын мэдээлэл: "Өрхийн эрүүл мэндийн төв"
3. Хэрэглэгчийн байршил.....5-р хороо.....
4. Барилгын нийт эзэлхүүн..... 1620 м³.....
5. Дулааны хэрэглээ нийт 0, 047Гкал/цаг.....

А. Халаалт.....0,047.. Гкал/цаг..


Б. Салхилуулга0,.. Гкал/цаг...

В. Хэрэгцээний халуун ус ...0,.. Гкал/цаг

Г. Технологийн хэрэглээ...0.....Гкал/цаг

6. Техникийн нөхцөл олгохыг зөвшөөрсөн нийт дулааны ачаалал 0,047 Гкал/цаг
 7. Холболтын ажлыг гүйцэтгэх явцад хангагчын төлөөлөгчөөр хяналт тавиулж ажиллах ба хяналтыг хийлгээгүй тохиолдолд ажлыг хүлээж авахгүй.
 8. Сувагжилтыг стандартын дагуу хийж гүйцэтгэхээр зураг төсөлд тусгах
 9. ДШСүлжээг барихад газар доорхи шугам сүлжээг зөөх, дайрч гарах, зам бут сөөг эвдэхэд тэдгээрийг заавал сэргээх ба гарах зардлыг төсөвт тусгаж сэргээх шаардлагатай.
 10. Гадна дулааны шугам ба дотор системийн угаалт, шахалт туршилтын ажлын зардлыг зураг төсөвт тусгасан байх, угаалт шахалт туршилтын үед дулааны шугам сүлжээний хэсгээс төлөөлөгч заавал байлцуулах шаардлагатай.
 11. Энэхүү техникийн нөхцөл нь олгосон өдрөөс хойш 2 жилийн дотор хүчинтэй. Хугацаа дууссан үед захиалагч байгууллага нь "БНДС" ТӨХК-ийн захиргаанд асуудал тавьж сунгуулах буюу дахин шинээр техникийн нөхцөл авах асуудлыг шийдвэрлүүлнэ.
 12. Зураг төсөлд хяналт тавиулан батлуулах.
 13. Уг объектыг барих талаар дээд байгууллагын зохих тогтоол шийдвэрийн заалтыг тусгана.
- Багануур дүүргийн засаг даргын 2017.06.22-ны №А/242 тоот захирамжийг үндэслэн олгов.

Боловсруулсан: ДШСА-ны дарга.....Э.Эрдэнэбат



БАТЛАВ.
БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.МӨНГӨНХӨЛӨГТ



ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2021 оны 12-р сарын 08-ны өдөр

№ БН 21/21

Багануур дүүрэг

**1. Техникийн нөхцөл
хүссэн хуулийн этгээд:**

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР

2. Хэрэглэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Багануур дүүрэг, Наран
хороолол, 1-р хороо
Утас: 70210017, 99263282

**3. Хэрэглэгчийн байршил,
зэрэглэл:**

Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 5-р хороо
нарийн гэр хороолол
3-р зэрэглэл

**4. Ажил үйлчилгээний
зориулалт:**

5-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн гадна
цахилгаан хангамж

**5. Техникийн нөхцөл
олгох үндэслэл:**

2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 03/342
тоот албан бичиг

6. Хэрэглээний нийт чадал:

56 кВт

7. Холбогдох цэг:

7.1 6 кВ-ын РП-2 хаалттай хуваарилах
байгууламжийн ячейк №7 Задгай-1 6 кВ ЦДАШ-ын
тулгуур №19 болон КТПН-18 дэд өртөө хүртэлх
3 тулгуурийг төмөр бетон болгон шинэчилнэ.

7.2 Шинэчилсэн 6 кВ-ын ЦДАШ-ын төгсгөлийн
тулаастай тулгуураас салбарлаж хуурай
салгуураар дамжуулан 3*50 мм²-аас багагүй
хөндлөн огтлолын талбайтай газарт булах
зориулалттай цахилгаан дамжуулах кабель шугам
татна.

7.3 6 кВ-ын РП-2 хаалттай хуваарилах
байгууламжийн ячейк №7 Задгай-1 6 кВ ЦДАШ-ын
тулгуур №19-өөс тэжээлтэй КТПН-18 **250 кВА**
чадалтай 6/0.4 кВ-ын дэд өртөөний хүчин чадлыг
нэмэгдүүлж, **400 кВА** чадалтай 6/0.4 кВ-ын КТПН
маягийн дэд өртөө шинээр суурилуулна.

7.4 Шинээр суурилуулсан 6/0.4 кВ-ын дэд өртөөний 6 кВ талд ачаалал таслагч, гал хамгаалагч, цэнэг шавхагч, 0.4 кВ талд нь ачаалалдаа тохирсон ерөнхий рубильник, гал хамгаалагч, гаргалгааны автомат бүхий 0.4 кВ-ын иж бүрэн тоноглол суурилуулна.

7.5 Шинээр угсарсан дэд өртөөний 0.4 кВ талаас ачаалалдаа тохирсон газарт булах зориулалттай 0.4 кВ-ын кабель шугам татаж өрхийн эрүүл мэндийн төвийг цахилгаан эрчим хүчээр хангана.

8. Тоолуур хэмжих хэрэгсэл:

8.1 6/0.4 кВ-ын дэд өртөөний 0.4 кВ талд Монгол улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс загварын туршилтанд орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан IEC 61861-1 стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, RS-485, PLC болон GSM /3G, 4G/-р гадны төхөөрөмжтэй холбогдох боломжтой IEC 62053 стандартын шаардлага хангасан өндөр нарийвчлалтай, санах ойтой, олон үйлдэлтэй 5 А-н ухаалаг тоолуур суурилуулна.

9. Тусгай заалтууд:

9.1 Шинээр угсрах 6 кВ-ын ЦДАШ, кабель шугам, 6/0.4 кВ-ын дэд өртөөний ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн, техникийн нөхцөл олгогчоор хянуулж, магадлан хяналтаар баталгаажуулна.

9.2 Шинээр угсрах 6 кВ-ын ЦДАШ, кабель шугамын трассын зураг, схемийг Багануур ЦТСС-ын инженер техникийн ажилчидтай хамтран гаргана.

9.3 Шинээр баригдах 6/0.4 кВ-ын дэд өртөөнд "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.41-н дагуу эсэргүүцэл нь 4 Ом-оос ихгүй байхаар газардуулга хийнэ.

9.4 Шинээр угсрах 6 кВ-ын ЦДАШ, кабель шугам, 6/0.4 кВ-ын дэд өртөө нь бусдын эзэмшлийн газар, инженерийн байгууламжийг огтлолцож байгаа цэгүүдэд холбогдох эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл авна.

9.5 Багануур дүүргийн газрын албанаас шинээр баригдах 6/0.4 кВ-ын дэд өртөөний байрлал, 6 кВ-ын ЦДАШ, кабель шугамын трассын дагуу газрын зөвшөөрөл авч баталгаажуулан мэдээллийн нэгдсэн санд оруулна.

9.6 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдлийн түвшингийн $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй, орчин үеийн шинэ тоног төхөөрөмж суурилуулна.

9.7 6 кВ-ын ЦДАШ, кабель шугам болон 6/0.4 кВ-ын дэд өртөөний барилга угсралтын ажлыг “Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл”-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.8 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай хэмжилт туршилтыг БЗӨБЦТС ТӨХК-ийн Багануур ЦТСС-аар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

9.9 6 кВ-ын РП-2 хаалттай хуваарилах байгууламжийн ячейк №7 Задгай-1 6 кВ-ын гаргалгааны реле хамгаалалтын тавилын тооцоог БЗӨБЦТС ТӨХК-р хийлгэнэ.

9.10 Хэрэглэгч нь 6 кВ-ын РП-2 хаалттай хуваарилах байгууламжийн ячейк №7 Задгай-1 6 кВ-ын гаргалгааны гүйдлийн трансформаторын ачааллыг тооцож, шаардлагатай тохиолдолд гүйдлийн трансформаторыг солино.

9.11 Тухайн хэрэглэгч нь түгээх сүлжээнд холбогдсон нөхцөлд цахилгааны хэрэглээ, цахилгаан тоног төхөөрөмжийн ажиллагаа нь түгээх сүлжээний үндсэн параметр болох хүчдэл, давтамжийн утганд нөлөөлж нэгдсэн сүлжээний дүрэмд заасан зөвшөөрөгдөх утгаас хэлбэлзэх, огцом буурах, өсөх, тоноглолын ачаалагдах хэмжээ зөвшөөрөгдөх хязгаараас давах мөн байгалийн онц ноцтой хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн түгээх сүлжээний үйл ажиллагаа доголдох, саатах нөхцөл байдал үүссэн тохиолдолд түгээх сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангахын тулд хугацаа харгалзахгүй цахилгаан эрчим хүчээр хязгаарлах, түдгэлзүүлэх нөхцлөөр холбогдоно.

9.12 Шинээр суурилуулах 6/0.4 кВ-ын КТПН маягийн дэд өртөөний хашааг цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу өргөтгөж, стандарт хэмжээнд бариулна.

9.13 Шинээр баригдах 6 кВ-ын ЦДАШ-ын төмөр зам, холбооны шугамтай огтлолцож буй хэсэгт өндөрлөгөөтэй төмөр бетон тулаастай тулгуур угсарна.

9.14 6/0.4 кВ-ын 250 кВА чадалтай дэд өртөөг буулгах тээвэрлэх зардлыг хэрэглэгч хариуцна. Дэд өртөөг тээвэрлэж, буулгах байрлалыг Багануур ЦТСС-ын инженер техникийн ажилчидтай зөвшилцөнө.

10. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэний дараа “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 4.22, 4.23 дугаар заалт, БЗӨБЦТС ТӨХК-ийн “Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам”-ын дагуу холбогдоно.

10.2 Цахилгаан тоноглол болон агаарын шугам, кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар БЗӨБЦТС ТӨХК-ийн Багануур ЦТССалбарын шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

10.3 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.4, 30.1.7, 30.1.8 дугаар заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

10.4 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.5 Хэрэглэгч нь “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.3 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

10.6 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

10.7 Хэрэглэгч нь “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн 4.2.72, 4.2.73, 4.2.74-р заалтуудыг баримталж угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

10.8 Эрчим хүчний сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 03 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам”-ын 5 дахь хэсэгт заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. 5.2 Техникийн нөхцлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

5.2.1 Техникийн нөхцөл авахын тулд техникийн хэрэглээний өгөгдлүүдээ зориуд буруу тодорхойлсон.

5.2.2 Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон.

5.2.3 Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд.

5.2.4 Хугацаа дууссан техникийн нөхцлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.

5.2.5 Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтийг ажлын хэсэгт гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцлийг хүчингүйд тооцно.

10.9 Техникийн нөхцөлд тусгагдсан заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд техникийн нөхцлийг хүчингүйд тооцно.

10.10 Техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэн түгээх сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийж гүйцэтгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

Хянасан: ТҮАХТэргүүн дэд захирал,
Ерөнхий инженер



Г.Шүрэнчулуун

Боловсруулсан: ТНХИнженер



Л.Мөнх-Эрдэнэ



ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар: ТН-Б23 /2021

2021/12/07

Захиалагч байгууллага: БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗДТГ
Хэрэглэгчийн нэр: Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга
Харилцах утас: 7021017
1. Байршил: 5-р хороо Нарийн 1-р гудамж
2. Зориулалт: Холбооны үйлчилгээ авах
3. Холбооны хэрэгцээ: /урьдчилсан тооцоогоор/
Телефон тоо (ширхэгээр)

4. Техникийн онцгой нөхцөл: Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн МХС ХХК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга объектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

5. Техникийн үндсэн нөхцөл

- 5.1 МХС ХХК Багануур дүүргийн газрын ХШ-11-ийн хүрээний 17-14-р худгаас (Мал эмнэлэгийн байрны баруун урд талд байрлах 5-р хороо чиглэлийн худаг) шинээр баригдах Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга хүртэл шинээр 2ш дундын худаг, 2 эгнээ 110мм PVC яндангаар сувагчлал хийх ба сувагчлалын гүн 1,0-1,2м байна.
- 5.2 МХС ХХК Багануурын газрын ХШ-11-ийн SO-5-н 71-80 хосыг 11-р шүүгээний оролтын худагт байрлах муфтьнээс холболт хийж 10*0.4*2 JF маркын кабелиар одоо байгаа 2ш жижиг худаг, 3ш дундын худаг, 500м сувагчлал болон шинээр хийгдсэн худаг сувагчлалаар татаж тус барилгын техникийн өрөөнд оруулж холбооны хайрцагт төгсгөлийн төхөөрөмжид холбоно.
- 5.3 Техникийн нөхцлийн дагуу угсралтын ажлыг гүйцэтгэж техникийн актыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд тухайн чиглэлийн худаг сувагчлалыг шилжүүлэх, гадны гэмтэл саатал гарсан тохиолдолд гарах зардал болон хариуцлагыг МХС ХХК хариуцахгүй болно.
Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.

6. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:

- 6.1. Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх.
- 6.2. Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй болон хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж төсөв зурагт оруулах.
- 6.3. Кабелийн хуваарилах хайрцагны байрлалыг хэрэглэгчийн шугамын нягтралын цэгт болон техник ашиглалтын шаардлага хангахуйц байдлаар сонгон суурилуулахаар технологийн норм хэмжээг зааж оруулах.

7. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:

- 7.1. Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг МХС ХХК-ийн Багануур дүүргийн газрын Кабель шугамын инженерээр (Утас: 99009802) хянуулан баталгааг авсан байх.
- 7.2. Газар шорооны ажил гүйцэтгэхдээ Кабель шугамын инженер болон Ерөнхий инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актанд хавсаргах.
- 7.3. Кабель шугамын угсралт болон газар шорооны ажлыг эхлэхдээ МХС ХХК-ийн Багануур дүүргийн газрын ерөнхий инженерээс албан ёсны мэдэгдлийг авч кабель шугамын инженерийн хяналтан дор гүйцэтгэнэ.
- 7.4. Шинээр татсан кабель болон кробканд тэмдэглэгээг бүрэн хийсэн байх.
- 7.5. Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.
- 7.6. Хэрэглэгч холбох нөхцлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол улсын стандарт MNS 5471:2005 ерөнхий шаардлагын дагуу хийгдсэн, техникийн акты хамт гадна холбооны угсралтын ажлыг хүлээж авна. Шинээр хийсэн сувагчлалын трассыг Багануур дүүргийн Газрын албаны мэдээллийн санд оруулсан тодорхойлолт бичиг болон CD-г техникийн акты хамт МХС ХХК-ийн Багануурын газарт хүлээлгэн өгнө.

8. Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:

Шинээр хийгдсэн холбооны худаг сувагчлал болон кабель шугам нь хотын телефоны кабель шугамын сүлжээнд холбогдох тул:


- 8.1. Танай эдэлбэр газарт суурилуулагдсан холбооны сувагчлал болон кабелийн гадны механик гэмтэлээс хамгаална.
- 8.2. Уг сувагчлалын трассыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах.
- 8.3. Худаг сувагчлалд техникийн ашиглалтыг хоногийн ямар ч үед ажил үйлчилгээг шуурхай гүйцэтгэх боломжоор бүрэн хангах.

9. Техникийн нөхцлийг Багануур дүүргийн ЗДТГ-ын 2021 оны 11 сарын 25-ны өдрийн №03/343 тоот албан бичгийг үндэслэн олгов.

10. Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт шалгалт хийлгэж тогтоосон журмын дагуу МХС ХХК-ийн Багануурын газарт техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.


11. ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ НЬ ОЛГОСОН ӨДРӨӨС ХОЙШ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХҮЧИНТЭЙ.

Техникийн нөхцлийг хянасан:
Багануурын газрын Ерөнхий инженер



Ц.БОЛОРМАА

Боловсруулсан:
Багануурын газрын Кабель шугамын инженер



Б.НАРАНБААТАР

